

**МАРГААН МЭТГЭЭНИЙ ЖҮЖИГ НААДМЫН
АМАН УЛАМЖЛАЛ: ХОЛБОО БА ДАЙРАЛЦАА**

Г.Нандинбилиг

Түлхүүр үг: *Монгол, аман уламжлал, ардын жүжиг наадам, маргаан мэтгээн, шүлэг, холбоо, дайралцаа*

Үгийн цэц булаалдах маргаан мэтгээний жүжиг наадмын аман яруу найргийн зүйлд *холбоо шүлэг, шүлэгэн холбоо, хуурчдыг гартаах үгс, дайралцаан* зэрэг нэрээр уламжилж ирсэн, үгийн цэц булаалдан, шүлэглэн дуулж, харилцан тоглодог аман яруу найргийн уламжлалт хэлбэрүүдийг нэрлэж байна. Эдгээр уламжлалт хэлбэрүүд нь тоглогч талууд харилцан асууж хариулж, шүлэглэн дуулж, тоглон хэлэлцдэгээрээ жүжиг наадмын шинжтэйн зэрэгцээ бэлэн цэцэн үг хэл, түүх соёлын мэдлэгээрээ өрсөлдөгч талаа гартаах зорилготой байдгаараа маргаан мэтгээний урлагийн чанартай юм.

Холбоо шүлэг болон дайралцааныг судалсан манай ахмад судлаачид “XIX зууны дунд үесээр монгол ардын аман зохиолын зүйлд “Бэнсэн үлгэр” хэмээх нэгэн шинэ төрөл зүйл буй болжээ. Энэхүү бэнсэн үлгэрийг өгүүлэгч үлгэрч, хуурч нар нь зохиолынхоо баатрын элдэв сонин үйл явдлыг олон янзын хөг аялгуугаар шүлэглэж дуулж “Морь эмээллэх”, “Баатар хуяглах”, “Зам хөөх”, “Цоо хурах” гэх зэрэг өвөрмөц маягийн шүлэг буй болгожээ. Үүнийг “Холбоо шүлэг” гэж нэрлэдэг байна. Хуурч нар нь үлгэрийн эхэн, адаг, бүлэг салааны төгсгөлд янз бүрийн уран хошин шүлэг холбоо хэлэх нь олонтоо ба энэхүү үлгэрийн чимэг хачир болсон богино шүлэг нь ард олноо үлэмжхэн дэлгэрч, аман яруу найргийн төрөл зүйлийн маягтай болсон байна. ...Үлгэрч хуурч нар үзэгч олноо баясгах, өөрсдийн уран чадварыг хөгжүүлэхийн тулд бие биедээ бэрх асуулт тавьж шүлгээр мэтгэлцдэг нэгэн сонин сайхан ёс буй болжээ. Үүнийг *хуурчдыг гартаах үг* гэж нэрлэдэг юм. Үүнээс уламжлан хүүхэд багачууд хоорондоо мөн шүлэг холбоогоор марган цэцэрхдэг болов. Энэ төрөл зүйлийг “*Дайралцаан*” гэх бөгөөд зарим нутагт (харчинд) “Данкэ булаалдах” гэж нэрлэдэг байна” (Гаадамба, Цэрэнсодном, 1978:80) гэж эдгээр уламжлалыг бэнсэн үлгэрийн үүсэлтэй холбон тайлбарласан байдаг.

Бид энэхүү өгүүлэлдээ *холбоо* болон *дайралцааны* уламжлалын тухай аман түүх, хууч ярианы баримтад тулгуурлан, маргаан мэтгээний аман зохиолын зан үйлийн уламжлал, тоглолт хийгээд үзэгчдийн хүлээн авахуй, хүүхэд залуусыг сурган хүмүүжүүлэх үүргийн талаар тодруулахыг зорилоо.

1. Холбоо шүлгийн зан үйлийн уламжлал

Маргаан мэтгээний энэ урлагийн тоглолтын ерөнхий дүр зураг хийгээд зан үйлийн уламжлалаараа ураг хуримын соёлтой холбогдох тухайд мэдээлсэн нэгэн аман түүх бидэнд байна. Галавын үлгэрийг өвлөн дамжуулагч Баярын Чунраа өвгөний 1977 онд мэдээлснээр “*Айлын найран дээр шүлэгч цэцэн улс холбоо булаалдана гэж нэг нэгнээ үгээр өддөг юм.*

Шүлэг дайралцах ч гэж хэлдэг. Босоо зогсож байгаад гартаа алчуур бариад хөлс юмаа сэвж, хөлөө газар дэвсэж ирээд л сүртэй бараатай хэлэлцдэг¹ гэжээ. Энэ аман түүхийг өгүүлэгч Б.Чунраа нь Хорчин монголын Жирмийн чуулганы Сүргийн хошууны нутгаас 1940 оод оны үед Улаанбаатар хотод нүүж ирсэн хүн бөгөөд тус хууч яриаг 1977 оны 10-р сард МУИС-ийн багш С.Дулам тэмдэглэн авсан байна. Тус хууч ярианы мэдээллийг задлан шинжилж үзвэл юуны өмнө “Холбоо булаалдах” хэмээх “нэг нэгээ үгээр өдөн” нааддаг энэхүү тоглолтыг зан үйлийн уламжлалтай, тэр тусмаа монголчуудын найрын зан үйлтэй холбогдох тухай мэдээлсэн байна. Энэ мэдээлэл нь бидэнд монголчуудын хуримын зан үйл дэх “Үүдэн дарлагын үг” хэмээх худ ураг бололцож буй хоёр тал харилцан асууж хариулан мэтгэлцэх жүжиг наадмын аман зохиолыг санагдуулж байна.

Жишээлбэл, 1968 оны “Музей судлал” сэтгүүлд хэвлэгдсэн Дарьгангын хуримлах зан үйлийн аман холбоо шүлгийн жишээ болох “Үүдэн дарлагийн үг”-нд

Хүргэн тал: Эртний түүхээс эргэн санаж

Эрхэм ургийн нөхдөөс

Энэ хэдэн зүйлийг асууя.

Анх тэргүүн галбыг

Аль төр эзэлсэн бэ?

Алтан сүмбэр уул

Аль талд нь тогтсон бэ?

Анамад мөрөн далай

Аль талаар нь урссан бэ?

Агар зандан мод

Аль талд нь ургасан бэ?

Наад үгийнхээ учрыг

Надад хэлж өгнө үү?

Бэрийн тал: Эзэлсэн төрийг асуухдаа та

Энэ галбаас осолдов уу?

Эрдэнэт сүмбэр уулыг асуухдаа

Эх нутаг чинь давчдав уу?

Арван хоёр зандан модыг асуухдаа

Аргал түлш чинь дутагдав уу?

Анамад мөрөн далайг асуухдаа

Ухсан худаг минь ширгэж,

Ус ундаар ядрав уу?... (МАЗҮАЗ², 1987: 304)

гэхчлэн худ ураг бололцогч талууд “Алтан сүмбэр уул”, “Анамад мөрөн далай”, “Агар зандан мод” зэрэг галавын домгийн дүр өгүүлэмжээс нэрлэн, эртний домгийн мэдлэгийг тэнсэн сорих замаар оюун ухааны уралдуулдаг.

Хуурын холбоо шүлэг нь хурдан сэтгэх авьяас чадварыг сорих бөгөөд эхлэл, өрнөл, төгсгөл бүхий тогтмол бүтэцтэй. Тоглогчид бие биеэ өдөж шүлэг эхлүүлээд, харилцан мөрий тавилцаж баталсны дараа ямар сэдвээр тэмцэлдэхээ тогтон, эртний домог түүхээс татан хэлэлцдэг. Холбоо шүлэгт гол төлөв эртний домог болоод түүх соёлын мэдлэгээ

¹ 73 настай, хорчин монгол Баярын Чунраа өвгөнөөс 1977 оны 10-р сард МУИС-ийн багш С.Дулам тэмдэглэн авсан нь судлаачийн гэрийн номын санд хадгалагдаж байна.

² Монгол ардын зан үйлийн аман зохиол. 1987. Эмхэтгэн боловсруулж, удиртгал тайлбар бичсэн Х.Сампилдэндэв, ШУА., ХЗХ., Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар

тэнсэн сорьж, бэлнээр шүлэглэн хэлж мэтгэлцдэг. Шүлэгчид харилцан бие биеэ тэнсэн сорьж хэлэлцсэний дараа ямар сэдвээр мэтгэлцэхээ тогтоно. Тухайлбал домог зүй, соёлын мэдлэгээр мэтгэлцэх үү гэдгээ харилцан хэлэлцэхдээ Жишээ нь:

-Сүн далайг шалбааг байснаас хэлэлцэх үү?

Сүмбэр уулыг довон байснаас хэлэлцэх үү?

Галбарагчаа зандан мод

Газрын хаана ургасан юм

Галбинга гэдэг шувуу

Ямар модонд үүрлэсэн юм

Галба юун дээр тогтсон юм

Галбыг хэн эзэгнэсэн юм

Тэнгэр юун дээр тогтсон юм

Тивийг хэн эзэлсэн юм.

-Тив гэдэг чинь

Тэнгэр дээр тогтсон юм

Тивийн эзэн нь

Шагжамуни болсон юм

Галбарагчаа зандан мод

Газрын хүйсэнд ургадаг юм...³

гэхчлэн Сүн далай, Сүмбэр уул, Галбарагчаа зандан мод, Галбинга шувуу зэрэг ертөнцийн үүслийн домгийн анхан эртний дүрүүдийг нэрлэн асууж, өрсөлдөгч талаасаа домог зүйн мэдлэгийг нь тэнсэн сорьж байна. Энэхүү холбоо шүлэгт гарч буй домог зүйн ойлголтууд нь Дарьгангын хуримын зан үйлийн “Үүдэн дарлагын үг”-нд буй галавын домог зүйн асуултуудтай уламжлалын шууд холбоотой байна.

Мөн 1961 онд Дундговь, Дорноговь, Өмнөговь аймагт хийсэн аман зохиол, нутгийн аялгуу судалсан шинжилгээний ангийн цуглуулга дахь “Хуримын ерөөл”-д:

...Тэнцэлгүй дөрвөн тивийн дунд

Тэгш дөрвөн талтай Сүмбэр уул, түүний бэлд

Төрсөн бид бүгд ертөнцөд

Замбутивийг эзэлсэн

Чагарвади хаанд

Бөртгэлжин цэцэн хатныг буулгах төрд

Байгуулсан журам билээ... (МАЗҮАЗ., 1987: 308)

гэхчлэн ерөөлийн хундага өргөхийн учрыг түүх татан хэлж байдаг бол өмнө өгүүлсэн “Үүдэн дарлагын үг”-нд гэрийн үүдийг баганаар дарсны учрыг бэрийн талаас шүлэглэн асуухад хүргэний тал:

Арван хорын үндсийг таслагч

Анжаа мэргэн Гэсэр хаан ч

Урангоо нэрт хатнаа

Урьж залж буулгахдаа

...Асар их зандан гэрийн үүдийг

³ 73 настай, хорчин монгол Баярын Чунраа өвгөнөөс 1977 оны 10-р сард МУИС-ийн багш С.Дулам тэмдэглэн авсан нь судлаачийн гэрийн номын санд хадгалагдаж байна.

*Ацтай шүрэн баганаар
Арлан дарж байсан
Алтан ацтай мөнгөн баганаар
Аяслан дарж хэдэн үгээ хэлэх чинь
Чи бид хоёрын жам биш
Цөм олны жамаа... (МАЗҮАЗ., 1987:302)*

гэхчлэн түүх татаж хэлэлцэж байна.

Харин холбоо шүлгийн түүх хэлэлцэх хувилбаруудад аль цаг үеийн ямар улсын түүхээс хэлэлцэхээ харилцан асууж тохирдог хэллэг байна. Одоогоор олоод байгаа хувилбараас үзвэл *Тан улс, Гурван улсын болон Монгол улсын* түүхийг нэрлэн асууж, өрсөлдөгч талаасаа түүхийн мэдлэгийг нь тэнсэн сорьдог нь харагдаж байна. Жишээлбэл, Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном нар “Монгол ардын аман зохиолын дээж бичиг”-гээ Дорнод аймгийн Баянтүмэн сум нэгдлийн гишүүн, ардын ерөөлч Ч.Жигмид, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум нэгдлийн гишүүн бага Ринчен нараас тэмдэглэн авснаа нэгтгэн “Өнөр цэцэг” сэтгүүлийн 1958 оны 6 дугаарт нийтлэгдсэн “Дан холбоо”-той харьцуулан сийрүүлж авсан бөгөөд хоёр дахь удаагийн хэвлэлд дайралцааны эхний хэсгийг Хэл зохиолын хүрээлэнгээс 1973 онд Төв, Дундговь аймагт явсан шинжилгээний ангийн шинэ олдвор цуглуулгаар засаж баяжуулснаа мэдээлсэн байдаг. Тус хувилбарт:

*-Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ
Тал талын хөвөөн дээр
Таши наагаад хэлэлцэнэ үү
Тан улсаас аваад
Түүх татаад хэлэлцэнэ үү
Гол голын хөвөөн дээр
Гоош⁴ наагаа хэлэлцэнэ үү
Гурван улсаас аваад
Түүх татаад хэлэлцэнэ үү... (Гаадамба, Цэрэнсодном 1978:83)*

гэхчлэн *Тан улс, Гурван улсын* түүхээс хэлэлцэхээр байгаа бол ахмад зохиолч Д.Баасанжав гуайн мэдээлсэн өөр нэгэн хувилбарт:

*- Дөрвөн далай усны зам
Андуу Гүмбэн зуугийн зам
Алалдаан тулалдаан цэргийн зам
Аль орноос хэлэлцэх вэ?
-Ээ, зээ, хүй, үнэхээр тийм үү дээ?
Холоос ирсэн холбооч чи
Хотол монголын түүхийг
Холбож шүлэглэж чадна уу даа
Алсаас ирсэн ирсэн холбооч чи
Амар шүлэглэж чадах уу даа
Агуу монголын түүхээс
Аваад холбохыг чинь үзье
-Ээ, зээ, хүй, үнэхээр тийм үү дээ?*

⁴ Зарлал бичиг гэсэн утгатай хятад гаралтай (gao-zi) үг байж магадгүй.

*Тэнгэрлэг эзэн Тэмүжингээс
Түүх татаж хэлэлцье
Түүний доорх хаадаас
Түрүүлж холбож чадна уу даа
Дэлхий даяарын улсаас
Дэс дараалан хэлэлцье
Дээд Юанийн мандсанаас
Дэлгэж байгаад холбоно уу... (Хэрлэн 2015:87)*

гэхчлэн хотол монголын түүхээс Юань улсын мандсан төрийг хүртэл хэлэлцэх бөгөөд *Бөртэ чино*, *Чингис хаанаас* эхлээд *Өгөдэй хааныг* хүртэлх түүхт хүмүүсийн нэр цол, гавьяаг дуудаж байна. Холбоо шүлэг нь ийнхүү харилцан асуулт хариулт байдлаар бие биеийнхээ домог, түүхийн мэдлэг болоод шүлэглэн холбох чадварыг тэнсэн сорьж байна.

Цаашилбал монгол хуримын “Үүдэн дарлагын үг”-нд

Хүргэн тал: *Галгүй буцалдаг тогоо хэдтэй ирэв?*

Гадаад далайг гаталгах

Ган шаахай хэдтэй ирэв?

Галуун сүүгээр шахсан

Хатсан бяслаг хэдтэй ирэв? (МАЗҮАЗ.,1987:304)

гэж асууж мэтгэлцдэг бол холбоо шүлэг хэлэлцэхэд мөн адил домог, түүхийн мэдлэгээ тэнсэн хэлэлцэхийн өмнө холбоо шүлэгт дуудан өдөхдөө:

Ламын хүрээг эвдэх гэж

Лантуу хэдтэй ирсэн бэ?

Нар гартал булаалдах гэж

Шүлэг хэдтэй ирсэн бэ?

Сүм хийдийг эвдэх гэж

Сүх хэдтэй ирсэн бэ?

Шөнө дөл болтол булаалдах гэж

*Шүлэг хэдтэй ирсэн бэ?*⁵

гэхчлэн асууж мэтгэлцдэг.

Эдгээр жишээнээс үзэхэд монголчуудын бэлэн цэцэлж мэтгэлцэх *холбоо* шүлгийн уламжлал нь анх хуримын зан үйлийн хүрээнд *аман холбоо* байдлаар үүсээд, хуурын үлгэрийн нөлөөгөөр хожим хувирч, *хуурын холбоо* хэмээх шинэ хэлбэрийг олсон байна.

Хуурчдын хэлдэг хэвшмэл хэллэг буюу хуурын холбоо шүлгийн үүргийн тухайд хуурын үлгэрийг дагнан судалсан БНХАУ-ын эрдэмтэн Б.Цогт (2002)⁶ судлаад, үлгэрийн үйл явдлыг ахиулах, үлгэрийн утга санааг лавшруулах, сонсогчийг сэтгэн бодуулах зай олгох, хуурчид амрах завшааныг олгох дөрвөн зүйлийн үйлдэлтэй болохыг нэгэнт судлан тогтоосон байдаг тул энд ярихгүй.

Холбоо шүлгийн тоглолт ба үзэгчдийн хүлээн авахуй

Ардын аман холбоо шүлэг нь хуурын үлгэрийн чимэг болж хувирсан гэвэл хуурын үлгэр гэдэг хүрээ дагаж хөгжсөн урлаг байсан бололтой. “*Дээр үед Богдын хүрээнд гамингийн*

⁵ 73 настай, хорчин монгол Баярын Чунраа өвгөнөөс 1977 оны 10-р сард МУИС-ийн багш С.Дулам тэмдэглэн авсан нь судлаачийн гэрийн номын санд хадгалагдаж байна.

⁶ Цогт. 2002. Хуурын үлгэрийн судлал. Эрдэмтдийн цуврал бичиг. Үндэстний хэвлэлийн хороо (монгол бичгээр).

цэргүүд орж ирсэн үед цагаан сарын өмнөхөн Цэцэн хан аймгийн Хардал жанжин бээсийн хошууны Наваан гэдэг өвгөн залуудаа нутгийн жинчдийг дагаж, нойр хоолгүй голдуу шөнөөр явсаар Хүрээнд ирж..., Тэгж яваад баахан улс бөөгнөрөөд байхаар нь очсон чинь хөгшин залуу хоёр хуурч хүн хоорондоо хэрэлдээд ч байх шиг, асууж хариулаад ч байх шиг, толгой холбон ярилцаж хуурдахыг сонссон (Хэрлэн, 2015: 93) тухайгаа 1961 онд хуучилсан нь ахмад зохиолч Д.Баасанжав гуайн хувийн архивд хадгалагдаж байна. Энэ хууч ярианаас үзэхэд, холбоо шүлгийг хуурдан мэтгэлцэх энэ урлаг нь тухайн үеийн халх монголчуудын хувьд шинэ содон зүйл байсныг гэрчилж байна.

Дээрх аман түүхэд байгаа өөр нэгэн үнэ цэнтэй зүйл бол хуурчдын тоглолтын талаар *“хоёр хуурч хүн хоорондоо хэрэлдээд ч байх шиг, асууж хариулаад ч байх шиг, толгой холбон ярилцаж хуурдах”* байдлыг дүрслэн хэлсэн мэдээлэл юм. Үүнийг Баярын Чунраа гуайн хуучилсан найрын зан үйлийн үед холбоо булаалдах тоглолтын тухай *“Босоо зогсож байгаад гартаа алчуур бариад хөлс юмаа сэвж, хөлөө газар дэвсэж ирээд л сүртэй бараатай хэлэлцдэг”* гэсэн дүрслэлтэй харьцуулбал ялгаатай байна. Эдгээр баримтаас харьцуулахад Чунраа гуайн хууч ярианд мэдээлж байгаа *“гартаа алчуур бариад”* тоглох тоглолт нь ямар ч хуур зэмсэггүй, аман холбоо шүлгийн тоглолт байгаа бол, Наваан гуайн хууч ярианд мэдээлж байгаа тоглолт нь хуурын холбоо шүлэг юм уу, магадгүй дайралцааны тоглолт байсан бололтой байна. Эндээс бидэнд илэрхий ойлгогдож байгаа гол зүйл бол анх найр хуримын зан үйлийн хүрээнд үүссэн ардын *“Аман холбоо”* шүлгийн уламжлал нь хожим бэнсэн үлгэрийн нөлөөгөөр *“Хуурын холбоо”* болж хөгжсөн байна.

Түүнчлэн тухайн цагт хүрээний ардууд *холбоо* болон *дайралцааны* тоглолтыг хүлээн авахдаа эрс ялгаатай ханддаг байжээ. Мөн ахмад зохиолч Д.Баасанжавын мэдээлснээр *“Ордос, хөлөнбуйр, барга, үзэмчин, цахар хошуунд ихэд дэлгэрсэн дайралцааны хэд хэдэн бадаг байдаг ч хүрээнийхэн хэлдэггүй учир нь бэлгэдлийн зан ёстой холбоотой гэж үздэг. Хүрээнийхэн дайралцаан гэдэггүй шүлгэн холбоо гэж нэрлэдэг байсан”*⁷ гэжээ. Эндээс харахад монголчууд маргаан мэтгээний аман зохиолын энэхүү уламжлалыг *шүлгэн холбоо*, *дайралцаан* гэж хоёр ялган нэрлэж ирсэн нь бэлгэдлийн учир шалтгаантай байна. Тодруулж хэлбэл, тухайн үеийн хүрээнийхэн *“шүлгэн холбоо”*-доо илүү таатай, *“дайралцаан”*-д тааламж муутай хандаж байсан нь илэрхий байна. Наваан гуайн хууч ярианы *“хэрэлдээд ч байх шиг”* гэсэн дүрслэл нь хуурчдын тоглолт нь холбоо шүлэг байсан уу, дайралцаан байсан уу гэдгийг таамаглах сэжүүрийг ч өгч байна. Холбоо, дайралцаа хоёр нь шүлэгчийн шууд аваад цэцлэх чадвар, үг хэлний цэцийг сорьж уралдуулах, өрсөлдөгч этгээдээ үг хэлээр гаргах зорилгоороо хоорондоо адил байна. Харин *“Аман холбоо”* болон *“Хуурын холбоо”* шүлгийн аль алинд тоглогч талууд эртний домог, түүхийн мэдлэгээ тэнсэн сорих зорилготой байдаг бол дайралцааны тоглогч талууд нь бие биесээ далд егөө үгсээр дайрч нэг нэгийгээ даван хэлэх зорилготой байна.

Чингэхдээ холбоо шүлэг, дайралцаан хоёрыг холбож байгаа нэгэн чухал дардас бол *“Зээ, хүү минь үнэхээр тийм үү дээ”* гэсэн тогтмол хэллэг болно. Тодруулж хэлбэл дайралцааныг тэмдэглэн хэвлүүлсэн бүхий л бичвэрүүдэд аман мэтгэлцээний асуулт хариултыг зааглаж буй энэ хэвшмэл хэллэг нь тоглогч дайралцааныг үргэлжлүүлж байгааг илтгэх уран сайхны асуулт болно. Мэдээжээр энэ нь тоглогчид хэлэх үгээ бодолхийлэх хугацааг өгөхийн зэрэгцээ мөн тоглогчдын дунд саяхан *холбоо* шүлэг хэлэлцэж өнгөрснийг мэдээлж байна. Эндээс таамаглахад, *холбоо* шүлгийн тоглолтод дийлдэж гартсан тал ялагдлаа хүлээн бууж өгөлгүй, хорон үгээр дайрч эхэлснээр *Дайралцаан* эхэлдэг байна. Үүнээс үзвэл *холбоо*, *дайралцаан* хоёр нь хоорондоо шууд холбоотой үүссэн, маргаан мэтгээний жүжиг наадмын аман яруу найргийн хэлбэрүүд болж байна.

⁷ Ахмад зохиолч, шүлэгч Д.Баасанжав гуайн хувийн архиваас 2005 оны 5-р сард Л.Хэрлэн бичүүлж авчээ (Хэрлэн Л. (2015) *Монгол харилцаа дууны зуун дээж*, 87-90 тал)

Маргаан мэтгээний аман зохиолын сурган хүмүүжүүлэх үүрэг

Монгол үгийн наадмыг хүүхдийн хэл яриаг тогтолцоотой хөгжүүлэх бие даасан хөтөлбөр шинжтэй (Нандинбилиг, 2021:152) гэж үзвэл *холбоо* шүлэг, *дайралцаан* зэрэг маргаан мэтгээний аман зохиол нь хүүхэд залуусыг эх хэлний дүрслэх ур маягийг чөлөөтэй хэрэглэж сурсны дараа хийсвэрлэн шүлэглэж, цэц булаалдах маргаан мэтгээний урлагт сургадаг гэж болно.

Холбоо шүлэгт мэтгэлцэгч талууд бие биеийн домог түүхийн мэдлэгээ тэнсэн сорьж хэлэлцдэг бол аль нэг тал нь гартаж дийлдэх үедээ бууж өгөлгүй үг хэлээ хурцлан дайрч эхэлснээр дайралцаа наадам болж хувирдаг бололтой. Тоглогч нь эсрэг этгээдээ дайралцаанд дуудаж байгаагаа илтгэж:

Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ

Дайралцвал дайралцъя

Даалин, хутгаан тавилцъя

Хэлэлцвэл хэлэлцье

Хэт хутгаа тавилцъя... (Гаадамба, Цэрэнсодном, 1978:83)

гэхчлэн хэлэхэд нөгөө талаас ах захаа мэдэж ёс зүй байхыг сануулсан утга бүхий шүлгийг хэлнэ. Дайралцаан эхлэх үеийн хариу шүлэгт:

Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ

Хөөе чи хүлээж бай

Хүний хэлэхийг сонсож бай

Аа чи хүлээж бай

Ахынхаа хэлэхийг сонсож бай... (Гаадамба, Цэрэнсодном, 1978:83)

...Хүүе дуу чи хүлээж бай

Хүний хэлэхийг чагнаж бай

Миний хэлэх үг чинь

Мэйрэн зайсангаас өөргүй шүү

Мөөгөн чинээ толгойд чинь

Мөндөр буучхаж мэднэ шүү⁸

гэхчлэн сурган сануулдаг.

Тоглогч талууд ийнхүү дайралцаж эхлэхийн хамтаар

-Арван тавны сарыг

Ар дээр гартал хэлэлцье

Адуу үхэр хоёрыг бэлчээрт гартал хэлэлцье

Хорин тавны сарыг

Хойд дээр гартал хэлэлцье

Хонь ямаа хоёрыг

Бэлчээрт гартал хэлэлцье... (Гаадамба, Цэрэнсодном, 1978: 84)

гэхчлэн хэлэлцээний болзоо мэлзээт цаг хугацлаа ч харилцан тогтдог тогтмол хэллэгүүд ч байна.

Мөн шударгаар тоглохоо харилцан баталж, хоёр талаас өөрсдийн үнэ цэнт эд эдлэлээр гэрч болгон, мөрий тавьж байгаагаа зарлаж байна. Жишээлбэл:

⁸ 73 настай, хорчин монгол Баярын Чунраа өвгөнөөс 1977 оны 10-р сард МУИС-ийн багш С.Дулам тэмдэглэн авсан нь судлаачийн гэрийн номын санд хадгалалдаж байна.

Буурал морио бууж өгье
Булган дахаа тайлж өгье
Хээр морио бууж өгье
Хэт хутгаа тайлж өгье⁹

гэхчлэн өөрсдийн унаж яваа хүлэг, өмсөж эдэлж яваа хувцас эдлэлээ амлан тавьдаг байна.

Энэхүү ам мөрийний үг хэллэг нь үгийн цэцэн, ухааны давуугаар ялж гарсан тал нь мөрийгөө авч, ялагдаж гартсан тал нь явган нүцгэн харихад хүрдэг байсан монгол эрчүүдийн хатуу тоглоомын харилцааг тусгаж байна.

Цаашилбал монголчуудын ёс зүйт харилцааны аман хуульд хүмүүс зөрчилдөж, хоорондоо хатуу үгээр хэлж дайралцах үед зөрчихөөс зайлсхийх гурван хил хязгаар, гурван даваа гэж бий. Энэ нь “Монгол хүний хамрыг гурав сөргөвөл уурлана” хэмээн хэлдэгчлэн “Энэ биеийн тэргүүнд халдах, эцэг эхийн удам сударт халдах, эзний онгон сахиус, шүтээнд халдах энэ гурав” байдаг билээ. Дайралцаанд тоглогч талууд бие биеийнхээ хор шарыг малтан, бие биеэ давахын тулд битүү егөө үгсийг хэлж наадахдаа харилцааны аман хуулийн дээрх гурван цээрийг зориудаар зөрчиж, эхлээд энэ биед нь, дараа нь уг гарал, удам угсаанд нь, эцэст нь сахиус шүтээнд нь халдаж хэлэх замаар хүүхэд залууст харилцааны ёс зүйн гурван цээрийг таниулдаг байна.

Дайралцааны шүлэгт хамгийн эхлээд дан биеийг нь гоочлон хэлж, харилцан хөнгөн дайрч эхэлнэ. Жишээлбэл:

-Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ
Зурмантааны нүхэнд нь
Зургаан салаа байна уу даа
Зулзаган чиний цээжинд нь
Зургаан шүлэг байна уу даа...
-Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ
Алаг дааганы нүхэнд нь
Арван салаа байна уу даа
Анаа чиний цээжинд нь
Арван шүлэг байна уу даа... (Гаадамба, Цэрэнсодном, 1978:84)

Дайралцаа шүлэгт мэтгэлцэгч талууд бие биеийнхээ шүлгийн цэцийг тэнсэн өрсөлдөж, ам алдсан бардам үгсийг хэлэлцэх боловч далд утгаар домог зүйн ой дурсамжаа сануулж байдаг. Жишээлбэл:

-Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ
Сарыг харваад алдвал
Саадаг бариад юу хийнэ
Чамтай хэлэлцээд гартвал
Шүлэг холбоод юу хийнэ... (Гаадамба, Цэрэнсодном, 1978:84)

гэхчлэн хэлэх нь эрт цагт нарыг харвахаар ам алдаад гартсан Эрхий мэргэний домгийн сургамжийг сануулж байна.

Мөн “Монголыг мохооё гэвэл моринд нь хэлэх”-ийн үгээр ямагт эр хүний унаж яваа хүлэг моринд нь халдаж хэлдэг. Жишээлбэл:

⁹ Төв халхын нутагт өргөн тархсан андгай үг.

-Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ

Гүү морийг унаад

Гүвээ давж чадах уу даа

Гүзээн толгойлж ирээд

Надтай хэлэлцэж чадна уу даа

Дааган морийг унаад

Даваа давж чадна уу даа

Давсан толгойлж ирчхээд

Надтай хэлэлцэж чадна уу даа... (Гаадамба, Цэрэнсодном, 1978:84)

гэхчлэн энэ шүлэгт “Эр хүн атал эм хүн адил гүү морийг уналаа, хүүхэд адил даага уналаа” гэсэн утгатай үгээр хорыг маажихын хамтаар “хол зам туулах бол гүү морь, дааган морь унаж хэрэггүй, амархан сульдаж цуцна” гэсэн мал ахуйн мэдлэгийг ч дамжуулж байна.

Дайралцаа шүлэг нь ухаан бодлоо уралдуулах наадам учраас бие биеэ үгээр давах гэж өрсөлдсөөр зөрчил туйлдаа хүрэх үед далд утгат үгсээр ёгтолж егөөдөн нэг нэгнийхээ хор шарыг малтах тогтмол шүлэглэлтэй байдаг. Тоглогчид нөгөө талаа илүү хорон үгээр давж, хор шарыг малтахын тулд:

-Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ

Эрээн эрээн илжиг чинь

Эмээлтэйгээ мэнд үү дээ

Илжиг саадаг суулга чинь

Ёроолтойгоо мэнд үү дээ

Ногоон ногоон илжиг чинь

Ногттойгоо мэнд үү дээ

Нохой саадаг суулга чинь

Ёроолтойгоо мэнд үү дээ

Алаг алаг илжиг чинь

Ногттойгоо мэнд үү дээ

Аалз саадаг суулга чинь

Ёроолтойгоо мэнд үү дээ... (Гаадамба, Цэрэнсодном, 1978:84)

гэж монгол хүний эрхлэх мал аж ахуйн соёлд нь халдан хэлж болно. Монгол дайралцааны мэтгэлцэгчээ гартаах үгэнд цаад хүнийхээ энэ ганц биеийг бус, угсаа гарвал, удам судар руу нь давшилж, ёс зүйт харилцааны хоёр дахь аман хуулийг зөрчих замаар тухайн хүнийхээ хор шарыг малтдаг байна. Тодруулж хэлбэл тухайн хүнийг монгол соёлын хүн биш болгон мохоож байгаа төдийгүй “Хэрвээ та монгол хүн юм бол унах морьтой, саах малтай байх ёстой бус уу? Танд унах морь, саах мал чинь байна уу?” гэсэн асуултыг уншигчид тавьж, хөрш зэргэлдээ үндэстэн угсаатнуудаас монгол соёлын хүний ялгарах ялгаа, онцлогийг таниулах давхар зорилгыг хадгалж байна. Илжиг бол хөрш хятадын аж ахуй, соёлын хамаатай амьтан байгаа бол нохой бол умар зүгийн нохой чаргалдаг эскимосчуудын соёлд гүнзгий хамаатай амьтан юм. Дайралцааны энэ шүлэгт монголчууд эдгээр үндэстэн угсаатнаас морь унаж, таван хошуу малаа сааж амьдардаг соёл заншлаараа ялгардаг болохыг таниулж байна. Энэ нь бусад үндэстэн угсаатныг доорд үзэж байгаа хэрэг огт биш, эдгээр амьтад нь тухайн соёлдоо үнэ цэнтэй, харин монголын соёлд бол морь мал нь үнэ цэнтэй гэдгийг ойлгуулах, цаашилбал хэрвээ монгол хүн илжиг унах юм уу нохой хөлөглөвөл монгол соёлын хүн биш болно гэдгийг хатуухан сануулж хэлж байна.

Тус шүлгийн хариуд нөгөө тал нь:

-Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ

Цагаан цагаан нохой чинь

Царман дээрээ галзуураг

Цагаан өвгөн бурхан чинь

Гүнгэрваандаа галзуураг... (Гаадамба, Цэрэнсодном, 1978:83)

гэхчлэн сахиус шүтээнд нь хүртэл халдан хэлж байна. Хэрвээ тоглогч бурхан тахил, сахиус шүтээнд нь халдан хэлсэн бол ёс зүйт харилцааны гурав дахь аман хуулийг зөрчсөн болно. Энэ нь монголчуудын “*Нохой гэр дээр гарах, гэрт оруулах, нохойг эсгий дээр хэвтүүлэхийг цээрлэх*” ёс заншил болоод энэ цээрийг зөрчвөл Цагаан өвгөн сахиус хилэгнэж, хүн малын хижиг өвчин тархаадаг гэсэн монголчуудын эртний шүтлэг бишрэлтэй холбоотой. Тэгвэл энэ дайралцааны шүлэгт бурхан шүтээн рүү нь дайран хэлснээрээ ёс зүйт харилцааны хилийг хүндэтгэн харилцаж сурахыг хүүхэд залууст тоглоом наадмын аргаар сануулсан байна.

Дайралцаан бол марган мэтгэлцэх харилцааны урлагийн жишээ мөн бөгөөд наадам өндөрлөхдөө :

-Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ

Уулан дээгүүр явдаг

Улаан халтар хэнийх вэ

Улсаас түрүүнд дуугардаг

Тэр золбин хэнийх вэ?..

-Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ

Уулан дээгүүр явдаг

Улаан халтар манайх аа

Улсаас түрүүнд дуугардаг

Тэр золбин танайх аа... (Гаадамба, Цэрэнсодном, 1978:84)

гэхчлэн нохой хуцсан төдий хэрэг байсан мэтээр төөрүүлж, хожил хоёр талдаа гээд, эв найртайгаар төгсгөдөг ёстой.

Дайралцаа шүлэг нь ийнхүү хүүхэд залуусыг маргаан мэтгээний урлагт сургах, үгийн цэц булаалдах, ёгтлол егөөдлийн аргаар утга далдалж хэлэлцэхэд сургах, цаашилбал маргаж мэтгэх харилцааны соёлд сурахыг чиглүүлсэн өвөрмөц нэгэн дасгал болж хөгжсөн байна.

Энэ бүхнээс дүгнэвэл,

Монгол ардын маргаан мэтгээний аман яруу найраг нь ардын хуримын зан үйлийн *аман холбоо* шүлгээс үүсэлтэй бөгөөд хожим хуурын үлгэрийн хөгжлийн нөлөөгөөр *хуурын холбоо* хэмээх шинэ хэлбэрийг олж хөгжсөн байна.

Холбоо, дайралцаа хоёр нь харилцан шүлэглэж мэтгэлцэх хэлбэрээрээ хоорондоо төсөөтэй ч агуулгын хувьд ялгаатай байна. *Холбоо* нь эртний домог түүхийн мэдлэгээ тэнсэн сорьж, цэц булаалдах мэтгэлцээний урлагийн шинжтэй байгаа бол *дайралцаа* нь далд егөө утгат үгсээр харилцан дайралцах маргааны урлагийн жишээ болж байна.

Ардын уламжлалт жүжиг наадмын эдгээр хэлбэрүүд нь хүүхэд залуусыг маргаж мэтгэх харилцааны соёлд сургахыг чиглүүлсэн өвөрмөц нэгэн дасгал болж хөгжсөн байна.

Summary

In this article, we aim to analyze the poetry of *Holboo* and *Dairaltsaa*, as well as the oral traditions of debate, the role of pedagogy, and the specifics of the performance, based on oral history or old-story facts. *Holboo* and *Dairaltsaa* are genres of debating plays and directly related to each other. The *Holboo* originates from traditional wedding rituals. The performance in *Holboo* probe their knowledge of ancient myths and history. *Dairaltsaa* teaches youngsters fast-paced profound debate, and the ability to include allegories into their verses. *Holboo* and *Dairaltsaa* help teach children the fluent use of figurative rhetoric in their speech by developing their debate capability.

Номзүй

- Ардын жүжиг наадмын аман зохиол.* 1988. Эмхэтгэн боловсруулж, удиртгал, тайлбар бичсэн Х.Сампилдэндэв. Редактор Д.Өлзийбаяр. ШУА., ХЗХ. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Гаадамба Ш., Цэрэнсодном Д.** 1978. *Монгол ардын аман зохиолын дээж бичиг.* ШУА ХЗХ., Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Монгол ардын зан үйлийн аман зохиол. 1987. Эмхэтгэн боловсруулж, удиртгал тайлбар бичсэн Х.Сампилдэндэв, ШУА., ХЗХ., Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Нандинбилиг Г., Дулам С.** 2020. *Монгол аман зохиолын онол-II: Хүүрнэн өгүүлэх аман зохиол, Жүжиг наадмын аман зохиол.* Улаанбаатар. МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Нандинбилиг Г.** 2021. *Монгол тоглоом наадмын аман зохиолыг хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх үүргийн үүднээс ангилах нь-Монгол судлалын чуулган.* МУБИС., Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2021 он. №32. 137-153 тал. Улаанбаатар.
- Оюунбадрах Д.** 2007. *Монголын хүүхдийн уран зохиол.* Улаанбаатар.
- Цогт.** 2002. *Хуурын үлгэрийн судлал.* Эрдэмтдийн цуврал бичиг. Үндэстний хэвлэлийн хороо.
- Хэрлэн Л.** 2015. *Монгол харилцаа дууны зуун дээж.* Улаанбаатар.